

Иргэн та Санхүүгийн зохицуулах хорооны удирдлага болон албан хаагчид хандах бол...

- Санхүүгийн зохицуулах хорооны дарга, дэд дарга, Ажлын албаны дарга болон газар, хэлтсийн дарга нарт санал хүсэлт, гомдол, мэдээллийг амаар болон бичгээр гаргаж болно. Мөн цахилгаан шуудан, утас, факс, интернэт, холбоо мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан ирүүлэх боломжтой.
- Санхүүгийн зохицуулах хорооны дарга, ажлын албаны дарга сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоногийн Мягмар гаригийн 15.00-17.00 цагийн хооронд иргэдийг хүлээн авч уулзаж, санал хүсэлтийг сонсож, гомдол, мэдээллийг зохих журмын дагуу шийдвэрлэж байна. Мөн газрын дарга нар ажлын цагт /08.00-17.00/ иргэдийн санал хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авна.
- Удирдлага, албан хаагч, Хорооны үйл ажиллагаа болон холбогдох зохицуулалтын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой санал гомдлоо 51-261881 дугаарын утас болон www.frc.gov.mn сайтын “Зочны дэвтэр”-т хандан илэрхийлж болно. Мөн төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг 51-264444 дугаарын утсаар ажлын цагаар /08.00-17.00/ хүлээн авч байна. Шаардлагатай бол өргөдөл, гомдол хариуцсан ажилтантай Санхүүгийн зохицуулах хорооны байр/Засгийн газрын IVбайр/-ны 218 тоот өрөөнд очиж уулзан санал хүсэлтээ амаар болон бичгээр гаргах боломжтой.
- Бичгээр гаргасан гомдол, мэдээлэлд утга агуулгыг ойлгомжтой, гаргацтай, оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утасныхаа дугаарыг бичсэн байх ёстойг анхаарна уу. Харин хамтран гомдол, мэдээлэл гаргаж буй тохиолдолд хүн тус тусын гарын үсгээ зурсан байна.
- Иргэд, хуулийн этгээдээс өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, хянан үзэх, хариу өгөх болон шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуульд заасан журмын дагуу хүлээн авч, хянанана.

Өргөдөл, гомдол хариуцсан ажилтан: Бичиг хэргийн эрхлэгч Д.Нандинцэцэг

Холбоо барих утас: 51-261881